

**БАТЛАВ.**

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН  
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Б.НАРАНТУЯА

**БАТЛАВ.**

МОНГОЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ  
ҮЭ-ИЙН ХОЛБООНЫ ДАРГА

Б.МЯГМАР

**СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ**

2017 оны 12-р сарын 04-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

2017 12 04 16 1

Нэг талаас Эрүүл мэндийн хөгжлийн төв /цаашид "Захиалагч" гэх/ нөгөө талаас Монголын эрүүл мэндийн ажилтны ҮЭ-ийн холбоо/цаашид "Гүйцэтгэгч" гэх/ нар харилцан тохиролцож, энэхүү гэрээг байгуулав.

**Нэг. Ерөнхий зүйл**

1. Монгол улсын Засгийн газраар батлагдсан "Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого"-ын хэрэгжилтийг хангах, мөн ЭМЯ-аас 2017 оныг НЭМ-ийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн НЭМ талаарх үзэл баримтлал, ойлголтыг нэгдмэл болгох, НЭМ тусламж үйлчилгээг хүргэх арга механизмыг боловсронгуй болгох, тусламжийн хэрэгцээг судлах, төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх шаардлагатай байна.

2. ЭМХТ-ийн үйл ажиллагааны чиг үүргийн хүрээнд болон хамтран ажиллах гэрээний 6.2 дахь заалт, энэхүү гэрээний хүрээнд 2017 онд хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу уг сургалтын гэрээ чиглэнэ. Энэ гэрээ нь **Захиалагч, Гүйцэтгэгч** нарын хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлоход оршино.

3. Гэрээний зүйл: ЭМХТ-ийн захиалгаар 2017 оны 12 сард явуулах "Эрүүл мэндийн эрх зүй ба эмнэлгийн мэргэжилтний ёс зүй" сургалтыг зохион байгуулах.

4. Гэрээний үнэ: "Эрүүл мэндийн эрх зүй ба эмнэлгийн мэргэжилтний ёс зүй" сургалтын зардал нь 5000.000/Таван сая / төгрөг байна.

**Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг**

1. Захиалагч нь сургалтын явцтай танилцах, шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, сургалтын чанар, зохион байгуулалтад хяналт тавих;

2. Батлагдсан төсвийн дагуу сургалтын зардлыг гүйцэтгэгч талын нэхэмжлэлийг үндэслэн цаг хугацаанд нь шийдвэрлэж тасралтгүй байдлыг хангах. Зарцуулалтад хяналт тавих;

3. Сургалтад хэрэглэгдэх хэвлэмэл материалыг цаг тухайд нь хэвлүүлэн нийлүүлэх;

4. Захиалагч нь ажлын захиалга өөрчлөх, хугацаа сунгах зэрэг тохиолдолд гэрээний нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж баталгаажуулна. Нэмэлт өөрчлөлт орсон хэсгээс бусад үндсэн гэрээний нөхцөлүүд хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

5. Сургалтын зохион байгуулалттай холбоотой доголдолтой зүйл гарвал Захиалагч доголдлыг арилгуулах, санал гомдлыг шийдвэрлүүлэх эрхтэй бөгөөд гарсан зардлыг нөхөн төлүүлнэ.



## Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

1. Гүйцэтгэгч нь захиалагчийн хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөр, удирдамж, сургалтын материал боловсруулан мэргэжлийн багаар сургалт явуулна.
2. Сургалтыг онол практик хослуулсан байдлаар, батлагдсан төсөвт багтаан сургалтын үйл ажиллагааг чанарын өндөр түвшинд зохион байгуулна
3. Суралцагчдын мэдлэг чадварын түвшинг дээшлүүлэхээр шинэ мэдээ мэдээллээр хангах сургалтын үр дүнг үнэлүүлэх
4. Захиалагчийн өгсөн сургалтын мэдээ, мэдээлэл, тоо баримтын нууцыг хадгалах өөр зориулалтаар ашиглах, бусдад шилжүүлэхийг хориглоно.
5. Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахдаа холбогдох хууль тогтоомж, стандартыг баримталж сургалтанд хамрагдаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудтай зөв боловсон харьцана.
6. Гэрээнд заасан хугацаанд сургалт зохион байгуулагдаагүй эсвэл алдаа дутагдал гарсан тохиолдолд хугацаа хоцорсон хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн нийт дүнгийн 0,2 хувиар алданги хүлээнэ.
10. Ажил гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий зүйлийн 2-т заасан өдрүүдэд багтаан сургалтыг зохион байгуулна.
11. Батлагдсан төсвийн дагуу сургалтын хэрэглэгдэхүүн, амт чанартай хоол хүнсээр хангана.
12. Сургалт зохион байгуулсан тайланг захиалагчид хүлээлгэн өгнө.

## Дөрөв. Бусад


1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
2. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх ба бичгээр үйлдэнэ.
3. Гэрээний явцад үүсэх аливаа маргаантай асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх ба харилцан тохиролцох боломжгүй тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

## ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн  
албаны дарга

  
З.Наранбаатар

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
Монголын эрүүл мэндийн ажилтны ҮЭ-  
ийн холбооны дэд дарга

  
Ч.Нарантуяа



**БАТЛАВ.**


ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН  
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

  
Б.НАРАНТУЯА

40419 9984231

**БАТЛАВ.**

МОНГОЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ  
ҮЭ-ИЙН ХОЛБООНЫ ДАРГА

  
Б.МЯГМАР

ТТГ №.6413  
1065793

**“ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРХ ЗҮЙ БА ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙ” СЭДЭВТ  
СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

**Нэг. Сургалтын зорилго**

Энэхүү сургалтын зорилго нь Эрүүл мэндийн байгууллагуудын ҮЭ-ийн хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын эрүүл мэндийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, ёс зүй харьцаа хандлагын талаар өргөн мэдлэг олгоход оршино.

**Хоёр. Сургалтын хугацаа**

Сургалт: Улаанбаатар хотод 12 дугаар сарын 13-ний өдөр зохион байгуулагдана. Эрүүл мэндийн салбарын эмч, ажилтнууд, ҮЭ-ийн гишүүд оролцоно.

**Гурав: Сургалтанд хамрагдах бүрэлдэхүүн**

Тус сургалтанд Монголын эрүүл мэндийн ажилтны ҮЭ-ийн холбооны гишүүн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ҮЭ-ийн гишүүд хамрагдана.

**Дөрөв: Сургалт зохион байгуулах журам:**

1. Сургалтанд хамрагдах хүмүүс нээлтийн ажиллагаанаас 30 минутын өмнө ирж бүртгүүлж орох
2. Сургалтын удирдамж болон зохион байгуулагчдын зүгээс тавьсан шаардлагыг биелүүлж оролцох
3. Сургалтын явцад бусдад дараа болохгүй байх (сургалтын дундуур гарч орохгүй байх, утасны дуу хаах гэх мэт)
4. Сургалтанд бүрэн хамрагдах
5. Сургалтын төгсгөлд сургалтанд бүрэн оролцсон хүн бүрт 2 багц цагийн гэрчилгээ олгоно.



**“ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРХ ЗҮЙ БА ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙ”  
СЭДЭВТ СУРГАЛТЫН ТӨСӨВ**

2017.12.04

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /₮-өөр/	Нийт үнэ /₮-өөр/
<b>Цайны зардал</b>				
1	Цай /кофе/	400	400	160000
	Печень /вафель	400	1200	480000
	Нэг удаагийн аяга, халбага	400	50	20000
	Сальфетка	5	3000	15000
				<b>675.000</b>
<b>Бичиг хэргийн зардал</b>				
2	Дэвтэр	200	1300	260000
	Үзэг	200	900	180000
	Хэвлэх олшруулах	1500	100	150000
	Бичгийн цаас	10	9500	95000
	Дасгалын цаас	1	20000	20000
	Ц/с үзэг	5	2000	10000
	Фломастер	10	2000	20000
	Гэрчилгээний үнэ	200	1200	240000
	Багшийн хөлс	8	30000	240000
	Өдрийн хоол	200	12000	2400000
	Анос			80000
	Заалны түрээс			600000
	Бусад зардал			30000
				<b>4325000</b>
				<b>5.000.000</b>

Хянасан: Дарга

Б.Мягмар

Төсөв хийсэн: Дэд дарга

Ч.Нарантуяа

